



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/486

Булган сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.2 дах заалт, Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дах заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дугаар заалт, Цусны донорын хөдөлгөөнийг дэмжигч хүндэт гэр бүл, байгууллага шалгаруулах тухай аймгийн ИТХ-ын хуралдааны 2014 оны 99 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, цус цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэхэд гэр бүл, байгууллага хамт олноороо идэвхи санаачлага гарган “Цусны донорын хөдөлгөөнийг дэмжигч хүндэт гэр бүл, байгууллага” шалгаруулах болзлыг хангасан байгууллага, гэр бүлийн жагсаалтыг хавсралтаар баталж, урамшуулсугай.

2. Урамшууллын зардалд шаардлагатай 2,700,000 (хоёр сая долоон зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010483

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын
14 өдрийн 148 дугаар захирамжийн хавсралт

“ЦУСНЫ ДОНОРЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖИГЧ ХҮНДЭТ ГЭР БҮЛ
БАЙГУУЛЛАГА” ШАЛГАРУУЛАХ БОЛЗЛЫГ ХАНГАСАН БАЙГУУЛЛАГА, ГЭР
БҮЛИЙН ЖАГСААЛТ

№	Овог нэр	Олговол зохих урамшуулал /төгрөг/	ХАОАТ	Олгох урамшуулал
Цусны донорын хөдөлгөөнийг дэмжигч хүндэт байгууллага				
1	Бугат сумын Эрүүл мэндийн төв	300000	30000	270000
2	Булган сумын 4 дүгээр цэцэрлэг	300000	30000	270000
3	Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв	300000	30000	270000
Цусны донорын хөдөлгөөнийг дэмжигч хүндэт гэр бүл				
1	Б.Бямбажаргалын гэр бүл	200000	20000	180000
2	Ж.Сосорбурамын гэр бүл	200000	20000	180000
3	Ц.Баатарчулууны гэр бүл	200000	20000	180000
4	Б.Нансалмаагийн гэр бүл	200000	20000	180000
5	Н.Амгаланбаатарын гэр бүл	200000	20000	180000
6	Г.Анхбаатарын гэр бүл	200000	20000	180000
7	Ц.Батнасангийн гэр бүл	200000	20000	180000
8	Д.Гансүхийн гэр бүл	200000	20000	180000
9	Б.Мөнхтуяагийн гэр бүл	200000	20000	180000
НИЙТ		2,700,000	270,000	2,430,000